

“ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ-НҮҮДЛИЙН МАЛ АЖ АХУЙ” сэдэвт даян дэлхийн тогтвортой мал аж ахуйн хөтөлбөрийн олон талт түншүүдийн 8 дугаар хуралд Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Л.Элдэв-Очирын хэлэх үг

Эрхэм хүндэт төлөөлөгчид өө,

Та бүгдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая,

Монголчууд бид эцэг өвгөдөөс уламжлан маллаж ирсэн таван хошуу мал сүргийнхээ буян хишгийг мянга мянган жилийн туршид хүртсээр ирсэн ард түмэн билээ.

Манай улс сүүлийн 20 гаруй жил уул уурхайгаас ихээхэн хамаарах болсон нь эдийн засгийг солонгоруулах үйл ажиллагаа хумигдаж, гадаадын хөрөнгө оруулалт эдийн засагт нөлөөлөх болсон. Хөдөө аж ахуйн түүний дотор мал аж ахуйн салбарыг Монгол Улсын тэргүүлэх салбар болгон тогтвортой хөгжүүлэхэд төрийн бодлогыг эрчимжүүлэх, эрх зүйн таатай орчин бүрдүүлэхэд Улсын Их Хурал анхааран ажиллаж байна.

Монгол Улсын Их Хурал мал аж ахуйн салбарыг чухалчлан үзэж бодлого шийдвэрээ түүнийг тогтвортой хөгжүүлэхэд чиглүүлж байгаа энэ үед Даян дэлхийн тогтвортой мал аж ахуйн хөтөлбөрийн олон талт түншүүдийн ээлжит хурал Монгол Улсад маань зохион байгуулагдаж байгаад талархалтай байна.

Мал аж ахуйн салбарын суурь хууль гэж хэлж болох Малын генетик нөөцийн тухай, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулиудыг Улсын Их Хурлаас 2017 оны 12 дугаар сард баталж, энэ оны 6 дугаар сарын 1-ээс хэрэгжиж эхлээд байна.

Эдгээр хуулиуд хэрэгжснээр малын эрүүл мэнд, малын үүлдэр угсаа, үржил селекци, ашиг шим, малаас гарч буй түүхий эд, бүтээгдэхүүний чанар, хүнсний аюулгүй байдал, дотоод, гадаад худалдааны чөлөөт байдал, бүртгэл, хяналт зэрэг нилээдгүй олон асуудлыг цэгцэлж, зөв гольдрилд оруулна гэж харж байгаа. Мөн хуульд заасан бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийн хуваарилалт, хариуцлагын өөрчлөлтөөр мал аж ахуйн салбарын нэгдмэл бодлогыг хэрэгжүүлэх боломж бүрдэн үр дүнд хүрнэ гэсэн хүлээлттэй байна.

Малчин ардын маань нөр их хөдөлмөрийн үр дүнд эрдэнэт мал сүрэг маань өсөн үржиж 66,2 саяд хүрлээ. Бид мал маллах арга ухааны олон зуун жилийн баялаг туршлагатай хэдий ч малыг амьжиргааны тогтвортой эх үүсвэр тогтвортой болгох, уламжлалт өв соёлоо хадгалан дэлхийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицуулах орчин үеийн техник технологийн дэвшил, шинжлэх ухааны ололт амжилтыг нэвтрүүлэх зайлшгүй шаардлага үүсээд байна. Үүнд төр засгийн бодлогоос гадна олон улсын туршлага, санал санаачлага, хамтын ажиллагаа чухал гэдгийг онцлон тэмдэглэхийг хүсч байна.

Төрийн бодлогын хүрээнд малын махыг гадаадын улс орнуудад экспортлох үүгээр дамжуулан иргэдээ тогтвортой орлоготой болгоход малын эрүүл мэндийн

асуудал тулгамдаад байна. Малын бүртгэлийг зөв хөтлөх, вакцинжуулах, малчид малын эмчийн хамтын ажиллагаа нь та бүхний тогвортой орлоготой байх үндэс суурь юм.

Цаашид мал аж ахуйн бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлж, малчдын амьжиргааг сайжруулахад нөлөөлж байгаа олон хүчин зүйлсийн сөрөг нөлөөллийг бууруулах, эерэг үр дүнг дэмжих, шийдвэрлэх боломжтой асуудлуудыг цэгцлэн шийдэхэд Байнгын хороо анхаарал хандуулан ажиллаж байгаа.

Монгол Улсын Их Хурлын дарга М.Энхболд 2018 оны 02 дугаар сард сүү, цагаан идээгээ хэрэглэх үндэсний уриалгыг гаргасан. Манай улс 2016 онд 874.4 мян.тн сүү үйлдвэрлэсэн хэрнээ 8.0 орчим хувийг үйлдвэрийн аргаар боловсруулсан гэсэн чамлалттай тоо мэдээ байна. Улаанбаатар хотод ойр орших аймаг, сумын малчид, фермерүүд л сүүгээ тодорхой хэмжээгээр борлуулах боломжтой байгаа бөгөөд алслагдсан аймгийн малчид, фермерүүд сүүгээ худалдан борлуулах бололцоо хомс байна. Ийм учраас орон нутгийн сүүний нөөцөд тулгуурлан ажлын байр бий болгох, малчид, иргэдийн бодит орлогыг нэмэгдүүлэх төсөл хөтөлбөрүүдийг дэмжих талаар Улсын Их Хурал анхаарч ажиллаж байгааг тэмдэглэн хэлэхэд таатай байна.

Бид олон жил яригдсан Бэлчээрийн хуулийг эцэслэн баталж, газар нутгийн хөрсний үржил шим, элэгдэл, доройтлоос сэргийлэх, даацад нийцүүлэн мал аж ахуйн үйлдвэрлэлийг эрхлэх, бэлчээрийг зөв зохистой ашиглах, хамгаалах эзэнтэй, хариуцлагатай байх тогтолцоонд шилжих цаг ирсэн. Иймээс Бэлчээрийн тухай хуулийн төслийг Улсын Их Хурлаар хэлэлцүүлэх шаардлагатай байна.

Өнөөдрийн **“Тогтвортой хөгжил-Нүүдлийн мал аж ахуй”** сэдэвт хурлын төлөлөгчид та бүхнээс мал аж ахуйн салбарын хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулах олон санал, санаачлага гарч улмаар хамтын ажиллгааны шинэ чиглэл дэвшүүлнэ гэдэгт итгэлтэй байна.

Олон талт түншүүдийн 8 дугаар хурлын үйл ажиллагаанд амжилт хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

--- оОо ---